

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ.....	2
1	Аудитын тайлан	3
2.1.	Оршил.....	3
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	8
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Менежментийн захидал	9
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчилтэй асуудлын нэгтгэл.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА 401-Р
ХААЛТТАЙ ХОРИХ АНГИ-НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА Ш.БУЛГАН
ТАНАА

2019.02.25 № 06/232
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

1 Аудитын тайлан

2.1. Оршил

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн дарга Ш.Булган танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК нь ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газартай байгуулсан гурвалсан гэрээг үндэслэн аудит хийлээ.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 02-ноос 2019 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Монголиан бизнес рейтинг аудит ХХК-ийн ерөнхий захирал Д.Түмэнжаргал, чанарын хяналтын менежер Р.Цанжидмаа, аудитор А.Мөнхцоож, аудиторовын туслах Д.Энхжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Монголиан бизнес рейтинг аудит ХХК-д 2019 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 1/55 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг нь Монгол Улсын хуулийг хэлбэрлэлтгүй сахин биелүүлж, хорих ял эдлэх үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх, эмнэлгийн тусламж үйлчилгээг стандартын түвшинд үзүүлж, эрүүл мэндийг сахин хамгаалахад оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл: Эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд хоригдлыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж, эмчилгээ оношлогоо эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах гэж үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлжээ

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт өөрчлөлт гаргаагүй ба Нийгмийн даатгалын тухай хуульд нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд татварын хөнгөлөлтөд өөрчлөлт орсныг хэрэгжүүлж ажилласан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-нэгдсэн эмнэлэг нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Ординат” ХХК-ийн боловсруулсан “Юникус” санхүүгийн програм хангамж ашигладаг байна.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад

дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1,0 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус эмнэлэг нь төсвийн байгууллага, нийт зардал нь тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц суурь үзүүлэлт гэж үзсэнтэй холбоотой юм.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2018 оны нийт зардал 2,319,105.2 мянган төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 23,191.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь тухайн байгууллагын аудитын чиглэлүүдэд үзүүлж болзошгүй эрсдэлийг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	9,277.2	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.0	
3	Албан шаардлага өгсөн	0	0.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.0	
	Дүн	4	9,277.2	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

2.9. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

- ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаанд бүртгэлтэй 15 нэр төрлийн 1,169,210.9 мянган төгрөгийн барилга байгууламж ашиглагдахгүй байна. Эмнэлгийн зориулалттай уг байранд нь ШШГЕГ-ын Тусгай ажиллагаа, аюулгүй байдлын газар үйл ажиллагаа явуулж байгаа боловч тус байгууллага хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцсон бүртгэсэн байна.
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 526 дугаар тогтоолыг үндэслэж, тус эмнэлгийн бүтэц орон тооны нэгжийн бүрэлдэхүүн “Төр хур” амралт сэргээн засах сувилал нь бие даан үйл ажиллагаа явуулах болсонтой холбоотой байгууллагын хөрөнгөнд бүртгэлтэй 184,774.4 мянган төгрөгийн хөрөнгө балансаас балансад шилжсэн байна.

2.10. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 66 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,899,439.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,895,190.9 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь 4,248.2 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласнаас шалтгаалжээ. Үүнд: цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 4,248.2 мянган төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

Төсвийн орлогыг задалж үзвэл улсын төсвөөс 1,234,587.4 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 637,323.6 мянга, төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлого 23,279.9 мянга, нийт 1,895,190.9 мянган төгрөгийн орлоготой байна. Тайлант онд хөрөнгийн хандив тусламжийн 3,388.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй 101,304.3 мянган төгрөгийн орлоготой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор гаргасан удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих тогтолцоог хуулийн дагуу хангасан талаарх мэдээллийг шалгаж үзэхэд хуульд заасан хугацаанд жил улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг www.shilendans.gov.mn/ сайтад байршуулж, толилуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100.0 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

3.1. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

3.1.1. Илрүүлэлт

Туслах үйл ажиллагааны 235.8 мянган төгрөгийн орлогыг дутуу бүртгэж тайлагнасан нь хэмжилт, үнэлгээ, үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС 1.2 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.1.2. Эрсдэл

- Нягтлан бодох бүртгэлийн хууль, Сангийн сайдын баталсан заавар журмын заалт зөрчигдөх,
- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.1.3. Өгсөн зөвлөмж

Орлогыг үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн 1/117 албан бичиг ирүүлсэн.

3.2. Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт

Нэгдсэн эмнэлгийн даргын 2018 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн Б/12 тоот тушаалаар 4 ажилтанд 732.2 мянган төгрөгийн шагналт цалин олгож, 14.6 мянган төгрөгийн НДШ, 71.8 мянган төгрөг ХХОАТ нийт 86.4 мянган төгрөг ногдуулаагүй нь хэмжилт, үнэлгээ, үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлд 32.1.1-д “Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д "Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

3.2.2. Эрсдэл

- Татвар, шимтгэлийн хүү, торгууль хүлээх
- Хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх
- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.2.3. Өгсөн зөвлөмж

- Урамшуулал, шагналт цалингаас хуулийн дагуу татвар, шимтгэл ногдуулж төсөвт төлж байх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн 1/117 албан бичиг ирүүлсэн.

3.3. Зардлын данстай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт

Тус байгууллагын тайлант оны шатахууны зарцуулалтын байдлыг хянаж үзэхэд 1-3 дугаар сарын нийт 8,955.0 мянган төгрөгийн шатахууны тооцоо бодоогүй нь иж бүрэн байх, үнэлгээ, үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 дугаар тушаалын Маягт заавар батлах тухай 5-д “Тухайн байгууллага хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудасыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна, Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт хэтрэлтийг гаргана” гэж заасныг зөрчсөн байна.

3.3.2. Эрсдэл

- Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах
- Нягтлан бодох бүртгэлийн хууль, Сангийн сайдын баталсан заавар журмын заалт зөрчигдөх,
- Санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх үүрэг батламж мэдэгдлүүд зөрчигдөх

3.3.3. Өгсөн зөвлөмж

- Шатахууны тооцоог сар бүр бодож хэмнэлт, хэтрэлтийг тооцож байх.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн 1/117 албан бичиг ирүүлсэн.

3.4. Дотоод аудиттай холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт

Туслах үйл ажиллагааны орлогыг оны эхнээс өссөн дүнгээр бараа материалын тайлангийн маягтанд бүртгэсэн ба төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллах журмын зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү мөнгө хадгалсан нь хэмжилт, үнэлгээ, үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллах журмын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.4.2. Эрсдэл

- Нягтлан бодох бүртгэлийн хууль, Сангийн сайдын баталсан заавар журмын заалт зөрчигдөх.
- Санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх үүрэг батламж мэдэгдлүүд зөрчигдөх

3.4.3. Өгсөн зөвлөмж

- Батлагдсан стандарт маягтын дагуу сар бүр тайланг гаргаж, бэлнээр авсан туслах үйл ажиллагааны орлогыг ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав харилцах дансанд тушааж байх.

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн 1/117 албан бичиг ирүүлсэн.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	251,768,185.00	226,695,718.39
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,787,045.17	1,219,981.93
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	5,787,045.17	1,219,981.93
3121	Төгрөг	5,787,045.17	1,219,981.93
31211	Төрийн сангийн харилцах	5,767,045.17	1,199,981.93
31213	Арилжааны банк дахь харилцах	20,000.00	20,000.00
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	15,291,342.54	5,280,107.06
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	11,704,842.54	1,693,607.06
335	Бусад авлага	3,586,500.00	3,586,500.00
3351	Байгууллагаас авах авлага	3,586,500.00	3,586,500.00
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	230,689,797.29	220,195,629.40
351	Түүхий эд материал	61,123,467.77	104,552,104.56
35110	Тусгай зориулалттай материал	29,619,528.50	47,492,594.50
35130	Эм боох материал	31,503,939.27	57,059,510.06
354	Хангамжийн материал	149,750,329.52	93,752,524.84
35410	Бичиг хэргийн материал	3,883,646.36	4,042,330.00
35420	Аж ахуйн материал	73,000,020.74	62,481,742.10
35430	Сэлбэг хэрэгсэл	5,293,250.00	1,025,950.00
35440	Түлш, шатах тослох материал	4,465,000.00	4,245,000.00
35450	Барилгын засварын материал	23,526,410.86	899,844.00
35460	Хүнсний материал	38,465,731.56	18,600,180.20
35470	Бусад хангамжийн материал	1,116,270.00	2,457,478.54
35600	Мал амьтад	19,816,000.00	21,891,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,184,398,869.37	8,201,379,328.51
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,184,398,869.37	8,201,379,328.51
391	Газар		
392	Биет хөрөнгө	6,180,261,840.50	6,378,939,004.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,653,782,358.86	5,980,756,906.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	1,254,565,365.17	204,659,878.32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	184,221,000.00	210,571,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	126,323,558.00	169,811,283.91
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,093,032,329.46	1,127,723,929.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	548,393,034.28	704,910,540.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	253,518,702.00	252,003,642.00

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39208	Хуримтлагдсан элэгдэл	100,281,004.79	133,926,933.23
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	11,404,100.00	11,404,100.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,497,500.00	21,497,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	7,631,187.58	11,709,437.62
393	Биет бус хөрөнгө	4,137,028.87	1,822,440,323.75
39301	Програм хангамж	7,567,692.31	8,567,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	3,430,663.44	5,267,368.56
39303	Бусад биет бус хөрөнгө	-	1,819,140,000.00
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>6,436,167,054.37</u>	<u>8,428,075,046.90</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>19,380,320.17</u>	<u>4,760,035.93</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,380,320.17	4,760,035.93
413	Өглөг	19,380,320.17	4,760,035.93
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,596,879.00
4136	Бусад өглөг	19,380,320.17	3,163,156.93
41361	Байгууллагад төлөх өглөг	12,385,829.30	139,929.30
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	6,994,490.87	3,023,227.63
414	Урьдчилж орсон орлого	-	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>6,416,786,734.20</u>	<u>8,423,315,010.97</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	6,416,786,734.20	8,423,315,010.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	650,565,487.64	2,469,705,487.64
51101	Өмч: - төрийн	650,565,487.64	650,565,487.64
51106	Эздийн өмчийн бусад		1,819,140,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	5,529,940,872.50	5,099,403,421.38
51210	Өмнөх үеийн үр дүн	5,529,940,872.50	5,529,940,872.50
51220	Тайлант үеийн үр дүн	-	(430,537,451.12)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	236,280,374.06	854,206,101.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>6,436,167,054.37</u>	<u>8,428,075,046.90</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,265,400,286.44	2,026,541,281.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	220,884,348.44	129,645,321.66
120	Нийтлэг татварын бус орлого	206,357,708.07	126,256,502.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	153,465,924.00	125,589,502.66
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,624,131.00	24,285,157.49
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	143,841,793.00	101,304,345.17
120009	Бусад орлого	52,891,784.07	667,000.00
122	Тусламжийн орлого	14,526,640.37	3,388,819.00
122002	Хандив тусламж /гадаад/	14,526,640.37	3,388,819.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,044,515,938.00	1,896,895,959.47
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,362,259,000.00	1,234,587,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,362,259,000.00	1,234,587,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,800,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,800,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-
1330	Төсвийн захирагчдаас	38,885,138.00	24,984,945.47
133003	Хөрөнгийн	38,885,138.00	24,984,945.47
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	641,571,800.00	637,323,614.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	641,571,800.00	637,323,614.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,306,786,769.13	2,326,535,143.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,306,786,769.13	2,326,535,143.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,285,561,701.41	2,322,335,143.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,262,889,313.01	1,208,106,205.22
210101	Үндсэн цалин	881,160,713.50	852,667,205.22
210102	Нэмэгдэл	365,081,438.51	343,102,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,374,840.00	10,000,000.00
210104	Урамшуулал	2,272,321.00	2,336,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,454,029.84	33,401,331.76
210201	Тэтгэврийн даатгал	8,077,773.80	8,667,098.21
210202	Тэтгэмжийн даатгал	934,694.21	872,988.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,096,367.77	1,073,235.10
210204	Ажилгүйдлийн даатгал	183,332.06	190,697.93
210205	Эрүүл мэндийн даатгал	24,161,862.00	22,597,312.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,231,714.96	111,000,000.00
210301	Гэрэл, цахилгаан	60,083,852.00	52,154,041.82
210302	Түлш, халаалт	51,793,122.94	31,417,182.95
210303	Цэвэр, бохир ус	21,354,740.02	27,428,775.23
2104	Хангамж, бараа материалын зардал	79,874,866.97	99,120,620.54
210401	Бичиг хэрэг	7,204,920.00	14,375,036.36

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	45,296,000.00	44,414,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,032,524.38	4,232,189.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,800,000.00	4,440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	161,300.00	23,345,159.18
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	3,957,136.00
210408	Бараа материал акалсны зардал	22,380,122.59	4,356,500.00
2105	Нормативт зардал	368,516,035.77	375,688,685.82
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	208,413,713.33	191,085,963.01
210502	Хоол, хүнс	160,102,322.44	163,256,803.75
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	21,345,919.06
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	72,121,918.03	87,995,383.86
210601	Багаж, техник, хэрэгсэл	55,000.00	2,820,040.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	1,261,750.00
210604	Урсгал засвар	72,066,918.03	83,913,593.86
2107	Томилолт, зочны зардал	3,956,000.00	4,000,000.00
210702	Дотоод албан томилолт	3,956,000.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,152,290.00	31,616,972.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	819,900.00	29,237,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	900,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	999,190.00	644,772.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	101,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	318,200.00	318,200.00
210807	Газрын төлбөр	914,000.00	516,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	327,365,532.83	371,405,943.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	8,722,818.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,943,200.00	11,470,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	324,922,332.83	351,213,125.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,225,067.72	4,200,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	20,225,067.72	2,200,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	20,225,067.72	2,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	2,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(41,386,482.69)	(299,993,862.06)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	63,611,028.88	130,543,589.06
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	61,646,028.88	130,543,589.06
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,965,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(63,611,028.88)	(130,543,589.06)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(104,997,511.57)	(430,537,451.12)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,079,532,547.74</u>	<u>1,910,013,811.14</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,901,747.74	38,102,797.14
120	Нийтлэг татварын бус орлого	73,901,747.74	38,102,797.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,571,631.00	36,085,935.72
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,571,631.00	36,085,935.72
120009	Бусад орлого	53,330,116.74	2,016,861.42
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,005,630,800.00	1,871,911,014.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,362,259,000.00	1,234,587,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,362,259,000.00	1,234,587,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,800,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,800,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	641,571,800.00	637,323,614.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	197,839,000.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	641,571,800.00	439,484,614.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,048,885,922.74</u>	<u>1,902,743,974.38</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,048,885,922.74	1,902,743,974.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,999,985,855.02	1,898,543,974.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,250,968,338.06	1,202,677,342.09
210101	Үндсэн цалин	1,224,495,880.25	847,238,342.09
210102	Нэмэгдэл	20,037,590.78	343,102,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,328,000.00	10,000,000.00
210104	Урамшуулал	3,106,867.03	2,336,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,591,000.00	31,702,699.00
210201	Тэтгэврийн даатгал	30,591,000.00	5,636,367.24
210205	Эрүүл мэндийн даатгал	-	26,066,331.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	115,884,214.96	111,000,000.00
210301	Гэрэл, цахилгаан	60,083,852.00	52,154,041.82
210302	Түлш, халаалт	31,211,870.51	31,417,182.95
210303	Цэвэр, бохир ус	24,588,492.45	27,428,775.23
2104	Хангамж, бараа материалын зардал	74,585,104.38	99,487,100.00
210401	Бичиг хэрэг	7,874,980.00	10,971,700.00
210402	Тээвэр, шатахуун	43,000,000.00	43,399,600.00

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,071,024.38	4,232,189.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,800,000.00	4,440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,839,100.00	36,443,611.00
2105	Нормативт зардал	281,439,489.62	322,200,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	199,757,489.62	219,993,413.80
210502	Хоол, хүнс	81,682,000.00	102,206,586.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	177,980,727.00	59,240,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	31,223,942.00	3,368,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	5,051,200.00
210604	Урсгал засвар	146,756,785.00	50,820,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,956,000.00	4,000,000.00
210702	Дотоод албан томилолт	3,956,000.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,580,981.00	51,066,733.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,926,375.00	48,686,961.29
210803	Даатгалын үйлчилгээ	-	900,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	999,190.00	644,772.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	101,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	318,200.00	318,200.00
210807	Газрын төлбөр	30,236,216.00	516,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	17,170,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	5,470,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	11,700,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,900,067.72	4,200,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,586,600.00	2,200,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,586,600.00	2,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,675,000.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,675,000.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,638,467.72	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,638,467.72	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>30,646,625.00</u>	<u>7,269,836.76</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	28,074,500.00	11,836,900.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,074,500.00	11,836,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	28,074,500.00	11,836,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(28,074,500.00)</u>	<u>(11,836,900.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,572,125.00	(4,567,063.24)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,214,920.17	5,787,045.17
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,787,045.17	1,219,981.93

4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	650,565,487.64	236,280,374.06	5,529,940,872.50	6,416,786,734.20
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	650,565,487.64	236,280,374.06	5,529,940,872.50	6,416,786,734.20
C07	Тайлант үеийн үр дүн				
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	650,565,487.64	236,280,374.06	5,529,940,872.50	6,416,786,734.20
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	650,565,487.64	236,280,374.06	5,529,940,872.50	6,416,786,734.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,819,140,000.00			1,819,140,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,469,705,487.64	236,280,374.06	5,529,940,872.50	8,235,926,734.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт		617,925,727.89		617,925,727.89
D06	Үндсэн хөрөнгийн нэмэгдэл				
D08	Тайлант үеийн үр дүн			-430,537,451.12	-430,537,451.12
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,469,705,487.64	854,206,101.95	5,099,403,421.38	8,423,315,010.97

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,899,439,100.00	1,895,190,913.09	4,248,186.91	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,895,239,100.00	1,890,990,913.09	4,248,186.91	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	656,610,900.00	656,610,872.00	28.00	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,206,925,500.00	1,202,677,342.09	4,248,157.91	99.65
210101	Үндсэн цалин	849,823,300.00	847,238,342.09	2,584,957.91	99.70
210102	Нэмэгдэл	343,102,200.00	343,102,200.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
210104	Урамшуулал	4,000,000.00	2,336,800.00	1,663,200.00	58.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,702,700.00	31,702,699.00	1.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	-	5,636,367.24	(5,636,367.24)	
210205	Эрүүл мэндийн даатгал	31,702,700.00	26,066,331.76	5,636,368.24	82.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,000,000.00	111,000,000.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	52,000,000.00	52,154,041.82	(154,041.82)	100.30
210302	Түлш, халаалт	30,000,000.00	31,417,182.95	(1,417,182.95)	104.72
210303	Цэвэр, бохир ус	29,000,000.00	27,428,775.23	1,571,224.77	94.58
2104	Хангамж, бараа материалын зардал	100,367,100.00	100,367,100.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	11,000,000.00	10,971,700.00	28,300.00	99.74
210402	Тээвэр, шатахуун	51,767,800.00	43,399,600.00	8,368,200.00	83.84
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,600,000.00	4,232,189.00	367,811.00	92.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	4,440,000.00	(1,440,000.00)	148.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,999,300.00	37,323,611.00	(7,324,311.00)	124.4
2105	Нормативт зардал	322,200,000.00	322,200,000.00	-	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	220,000,000.00	219,993,413.80	6,586.20	100.0
210502	Хоол, хүнс	102,200,000.00	102,206,586.20	(6,586.20)	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,394,000.00	68,394,000.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,594,000.00	9,882,800.00	(288,800.00)	103.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,340,000.00	5,051,200.00	288,800.00	94.6
210604	Урсгал засвар	53,460,000.00	53,460,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	4,000,000.00	4,000,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	4,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	33,479,800.00	33,479,772.00	28.00	100.0

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	хураамж				
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,100,000.00	30,100,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	900,800.00	900,800.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	644,800.00	644,772.00	28.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,318,200.00	1,318,200.00	-	100.0
210807	Газрын төлбөр	516,000.00	516,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,170,000.00	17,170,000.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,470,000.00	5,470,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,700,000.00	11,700,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,200,000.00	4,200,000.00	-	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,200,000.00	2,200,000.00	-	100.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,200,000.00	2,200,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,899,439,100.00	1,895,190,913.09	4,248,186.91	99.78
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,234,587,400.00	1,234,587,400.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,234,587,400.00	1,234,587,400.00	-	100.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	641,571,800.00	637,323,614.00	4,248,186.00	99.34
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	197,839,000.00	(197,839,000.00)	
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	641,571,800.00	439,484,614.00	202,087,186.00	68.50
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	23,279,900.00	23,279,899.09	0.91	100.0
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,279,900.00	23,279,899.09	0.91	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	125	125		
620001	Удирдах ажилтан	3	3		
620002	Гүйцэтгэх ажилтан	122	122		

3. ХАВСРАЛТ

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчилтний асуудлын нэгтгэл

Огноо: 2019/02/22	Аудитын нэр:	ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2019/349/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		401 дүгээр хорих анги-Нэгдсэн эмнэлэг	мянган төгрөгөөр:

№	Алдаа зөрчлийн утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	3	4	5			9	10
1	Нэгдсэн эмнэлгийн даргын 2018 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн Б/12 тоот тушаалаар ажилтанд 732.2 мянган төгрөгийн шагналт цалин олгож, 14.6 мянган төгрөгийн НДШ, 71.8 мянган төгрөг ХХОАТ ногдуулаагүй нийт 86.4 мянган төгрөг байна.	86.4	Зөвлөмж өгөх			Дарга, ахлах нягтлан бодогч	Ш.Булган, Б.Баярмаа
2	Туслах үйл ажиллагааны 235.8 мянган төгрөгийн дэлгүүрийн орлогыг дутуу бүртгэсэн байна	235.8	Зөвлөмж өгөх			Дарга, ахлах нягтлан бодогч	Ш.Булган, Б.Баярмаа
3	Тус байгууллагын 1-12 дугаар саруудын шатахууны зарцуулалтад сорил хийхэд 1-3 дугаар сарын нийт 8,955.0 мянган төгрөгийн шатахууны тооцоо бодоогүй байна	8,955.0	Зөвлөмж өгөх			Дарга, ахлах нягтлан бодогч	Ш.Булган, Б.Баярмаа
4	Туслах үйл ажиллагааны орлогыг оны эхнээс өссөн дүнгээр бараа материалын тайлангийн маяганд бүртгэсэн байна.	-	Зөвлөмж өгөх			Дарга, ахлах нягтлан бодогч	Ш.Булган, Б.Баярмаа
	Нийт	9,277.2					

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 20 rows.

